



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/УСГ

Зуунмод

Халх голын ялалтын түүхт 80 жилийн  
ойд оролцох өсвөрийн дайчдын “Морин буухиа”  
аялалд оролцох сурагчдад дэмжлэг үзүүлэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 204 тоот тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийн жагсаалтын 1.2, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 210 тоот тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Халх голын ялалтын түүхт 80 жилийн ойд зориулсан Төв аймгийн Мөнгөнморьт сумаас Дорнод аймгийн Халх гол сум хүртэл 2019 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 20 хоногийн хугацаатай “Морин буухиа” аялалд оролцох сурагчид болон зохион байгуулах бүрэлдэхүүнд дэмжлэг үзүүлсүгэй.

2. “Морин буухиа” аялалд оролцох сурагчид болон зохион байгуулах бүрэлдэхүүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахыг аялалын багийн удирдагч Д.Буянбатад даалгасугай.

3. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах зардал 1,000,000 /Нэг сая / төгрөгийг шилжих үлдэгдлийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ю.Бямбацогт/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ